

МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

Бэлтгэл, сургалтын зардлын дээд хэмжээ батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэх, эсхүл дадлагажихад бэлтгэх бэлтгэл, сургалтын зардлын дээд хэмжээг 1,160,000 /нэг сая нэг зуун жаран мянга/ төгрөг байхаар баталсугай.

2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Дамбий/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Д.Чинзориг/, Салбарын хяналтын газар /Б.Нарангарав/-т тус тус даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

**“МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙГ ГАДААДАД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ, ЭСХҮЛ
ДАДЛАГАЖИХАД БЭЛТГЭХ БЭЛТГЭЛ, СУРГАЛТЫН
ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭ”**

ТАНИЛЦУУЛГА

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Бэлтгэл, сургалтын зардлын дээд хэмжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.” гэж заасан. Энэхүү хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэх, эсхүл дадлагажихад бэлтгэх бэлтгэл, сургалтын зардлын дээд хэмжээний төслийг боловсрууллаа.

Уг төсөлд санал авахаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас тусгай зөвшөөрөлтэй 71 байгууллагын дунд 2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулсан. Үүний дагуу төсөлд хэлэлцүүлэгт оролцсон 28 байгууллагаас санал ирүүлснийг харгалзан үзсэн.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Гадаадад хөдөлмөр эрхлэхэд бэлтгэх сургалт дараах агуулгатай байна” гэж заасан. Үүнд:

- хүлээн авагч улсын хууль тогтоомж, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, соёл, ёс заншлын талаар ерөнхий мэдээлэл болон хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай бусад мэдээлэл;
- хүлээн авагч улсын хөдөлмөрийн аюулгүй байдал, эвлэлдэн нэгдэх боломж, ажилтны төлөөллийн байгууллага болон төрийн бус байгууллагын талаарх мэдээлэл;
- эрүүл мэнд, нийгмийн даатгал, нийгмийн хамгааллын арга хэмжээ;
- болзошгүй эрсдэл, түүнээс хамгаалах арга хэмжээ;
- зуучлуулагчийн эрх, үүрэг, хариуцлага;
- шаардлагатай тохиолдолд холбоо барих байгууллагын мэдээлэл;
- Монгол Улсад буцаж ирсний дараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ;
- холбогдох бусад мэдээлэл.

Дээрх агуулгын хүрээнд энэхүү 5 өдрийн сургалт зохион байгуулахтай холбоотой гарах зардлын тооцоог “Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцоо”-ны дагуу ажилтан илгээх болон хүлээн авах тухай харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас Бүгд Найрамдах Солонгос Улсад Монгол Улсын иргэнийг зуучлахын өмнөх бэлтгэл, сургалтын зардал болон тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудаас ирүүлсэн саналыг харьцуулан боловсруулж, тусгасан болно.